



## ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2019.11.04 - 11.08

## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

**АНУ:** Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. Энэхүү өсөлт АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны хэлэлцээрийн 1-р үе шат амжилттай болно гэсэн хүлээлттэй холбоотой ба АНУ-ын урт хугацаатай бондын өгөөж болон компаниудын 3-р улирлын санхүүгийн үзүүлэлтүүд индексүүдэд эерэгээр нөлөөллөө.

Урт хугацааны хүүний төвшин өссөнөөс үүдэн банкуудын цэвэр хүүгийн зөрүү өссөн нь санхүүгийн салбарын компаниудын хувьцааны үнэ өсөхөд нөлөөлжээ. Харин урт хугацааны бондын өгөөж өссөн нь өндөр ногдол ашиг тараадаг үл хөдлөх хөрөнгө болон ус, цахилгаан, дулааны үйлчилгээ эрхэлдэг компаниудын хувьцааны ханшид сөргөөр нөлөөлжээ.

Бондын зах зээлд 10 жилийн хугацаатай Засгийн газрын өрийн бичгийн өгөөж 7-р сараас хойших дээд төвшинд хүрлээ. Шинжээчдийн үзэж байгаагаар худалдааны хэлэлцээртэй холбоотойгоор урт хугацааны бондын өгөөж өсжээ.

**Европ:** Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүдтэй адилаар АНУ болон БНХАУ-ын худалдааны хэлэлцээр болон компаниудын 3-р улирлын санхүүгийн үзүүлэлтүүдээс хамааран өсөлттэй хаагдлаа.

STOXX 600 индексийн сагсанд багтах компаниудын 80% нь санхүүгийн тайлангаа мэдээлсэн ба эдгээр компаниудын 50% нь шинжээчдийн таамгийг давжээ. Эрүүл мэнд болон түүхий эдийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй компаниудын ашигт ажиллагаа хамгийн ихээр шинжээчдийн таамгийг давсан бол ус, цахилгаан, дулааны үйлчилгээ эрхэлдэг компаниуд болон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний салбарын компаниудын ашигт ажиллагаа шинжээчдийн таамаглалаас доогуур байв.

**Япон:** Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй байлаа. Энэхүү өсөлт хөрөнгө оруулагчид АНУ болон БНХАУ-ын эрх баригчид гадаад худалдааны эхний шатны хэлэлцээрт ойрын хугацаанд гарын үсэг зурна хэмээх хүлээлттэй холбоотой.

Шинжээчдийн үзэж байгаагаар АНУ болон БНХАУ-ын гадаад худалдааны хэлэлцээр болон дэлхийн бусад орнуудын Төв банкууд бодлогын хүүгээ бууруулж байгаа нь ирэх жил дэлхийн эдийн засагт эерэгээр нөлөөлөх ч Япон улсын эдийн засаг агшсаар байх юм.

**БНХАУ:** АНУ болон БНХАУ-уудын гадаад худалдааны эхний шатны хэлэлцээрийн үр дүнд хоёр тал гаалын татварыг зарим нэг бараа бүтээгдэхүүнүүд дээр бууруулах болсон гэх мэдээнээс үүдэн БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа.

Гэвч долоо хоногийн сүүлээр гаалийн татварыг бууруулах асуудал дээр цагаан ордны эрх баригчид хуваагдмал байр суурьтай байгаа хэмээн мэдэгдэл гарсан нь хөрөнгийн зах зээлийн индексүүдийн өсөлтийг хязгаарласан байна.

**Эх сурвалж:** Troweprice.com

### Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	18,457.36	0.69% ▲
Dow Jones	АНУ	27,681.24	1.22% ▲
S&P 500	АНУ	3,093.08	0.85% ▲
Nasdaq	АНУ	8,475.31	1.06% ▲
S&P/TSX	Канад	16,877.42	1.71% ▲
FTSE 100	Их Британи	7,359.38	0.78% ▲
S&P/ASX 200	Австрали	6,724.10	0.82% ▲
Nikkei 225	Япон	23,391.87	2.37% ▲
Hang Seng	Хонг Конг	27,847.23	2.75% ▲

### Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	113.82
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	103.31
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	102.41
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	109.92
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	103.41
DBM' 2023	USD	7.250%	105.58
TDBM' 2020	USD	9.375%	102.54
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	97.90

### Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	1.760	-0.01 ▼
Libor 3M	1.900	0.01 ▲
Libor 6M	1.920	0.02 ▲
Libor 1YR	2.000	0.07 ▲
US 2YR Bond	1.674	0.09 ▲
US 3YR Bond	1.703	0.13 ▲
US 5YR Bond	1.746	0.17 ▲
US 10YR Bond	1.942	0.19 ▲

### Валютын ханш /төг/

Валют	2019.11.08	Өөрчлөлт
USD	2,702.87	0.07% ▲
CNY	386.99	0.86% ▲
EUR	2,986.00	-0.95% ▼
RUB	42.40	0.52% ▲
KRW	2.34	0.86% ▲
JPY	24.73	-1.16% ▼
CAD	2,049.73	-0.22% ▼

### Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,459.00	-3.65% ▼
Мөнгө /спот/	USD/t oz.	16.81	-7.26% ▼
Зэс	USD/lb.	268.20	1.09% ▲
Нүүрс	USD/MT	69.95	0.00%
WTI газрын тос	USD/bbl.	57.24	1.85% ▲
Brent газрын тос	USD/bbl.	62.51	1.33% ▲

### Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. IX	9.00%
Бодлогын хүү	2019. IX	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. IX	11.12%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. IX	11.37%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. IX	4.95%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. IX	16.91%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. IX	10.76%

**Эх сурвалж:** Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 47 компанийн 644.0 сая төгрөгийн 2,051,014 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Хорго хайрхан” /CHE/ компанийн хувьцаа 15.00%-аар буюу хамгийн ихээр өсөж 69.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Стандарт проперти групп” /BBD/ компанийн хувьцаа 14.29%-аар буурч 78.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 500 ширхэг үнэт цаас 50.5 сая төгрөгөөр арилжаалагджээ.

11-р сарын 8-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,436.5 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 18,457.36 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.69%-аар өссөн байна.



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

## Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

### Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	694.4
Зах зээлийн үнэлгээ	2,436,487.9

### Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	18,457.36	0.69% ▲
MSE I индекс	8,326.25	-2.19% ▼
MSE II индекс	7,663.44	2.45% ▲

### Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Ард санхүүгийн нэгдэл	114,701	197,404,215
АПУ	155,021	78,256,231
Мандал даатгал	12,096	58,092,205
Монгол савхи	76,729	49,873,850
Ард кредит ББСБ	610,388	48,335,613

### Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Хорго хайрхан	69.00	15.00% ▲
Ард санхүүгийн нэгдэл	1,763.00	14.55% ▲
Фронттиер лэнд групп	200.00	14.29% ▲
Атар-Өргөө	60,300.00	13.77% ▲
Ремикон	28.98	13.65% ▲

### Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Стандарт проперти групп	78.00	-14.29% ▼
Булган гурил тэжээл	800.00	-13.04% ▼
МИК Холдинг	11,000.00	-9.98% ▼
Авто импекс	1,698.00	-8.22% ▼
Талх чихэр	16,500.00	-5.71% ▼

### Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Ард Секюритиз	387,860,072
Би Ди Сек	273,378,078
Голомт Капитал	153,365,679
Централ Секьюритийз	102,633,000
Бумбат-Алтай	93,161,196

### Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	505.00	537,412
Таван толгой	6,595.00	347,327
МИК Холдинг	11,000.00	227,803
Говь	264.84	206,605
Инвескор ББСБ	2,081.00	149,266

## ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-20/06/20-A0260-15.14	500	50,450,000	100,900	100,900	156	15.140%

## НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.06.14-нд олгов
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дюти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.04.24-нд олгов
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.27-нд олгов
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.05.20-нд олгов
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.17-нд олгов
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.21-нд олгов
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	2019.07.19-нд олгов
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.07.26-нд олгов
28	TEE	Тээвэр дархан ХК	22.3	81.7	365.5%	500.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
29	ERS	Монгол алт ХК	6.3	39.9	631.2%	150.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
30	TTL	Таван толгой ХК	52,858.1	44,923.4	85.0%	853.0	2019.04.26	2019.04.01	2019.06.11-нд олгов
31	EER	Ариг гал ХК	449.3	109.4	24.3%	32.5	2019.04.26	2019.03.27	2019.09.30-ны дотор
32	HRM	Гермес центр ХК	481.3	447.7	93.0%	5.7	2019.08.15	2019.09.02	2019.09.18-нд олгов
33	SUU	Сүү ХК	5,706.4	1,143.4	20.0%	3.3	2019.09.09	2019.04.05	2019.10.24-нд олгов



## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

**“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци” ХК нь баян хөндий алтны төслийн урьдчилсан ТЭЗҮ-ийн эерэг үр дүнг танилцууллаа**

“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци” ХК (TSX:ERD | MSE:ERDN) (цаашид “Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани” гэх) нь Монгол улсын баруун өмнөд хэсэгт орших өөрийн 100% эзэмшлийн өндөр агуулга бүхий илээр олборлох боломжтой Хөндий Алтны Төслийн хараат бус техникийн тайланг танилцуулж байна.

Энэхүү техникийн тайланд Баян Хөндий ордын (“Bayan Khundii”) урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл (“урьдчилсан ТЭЗҮ”, “PFS”) болон Баян Хөндийгөөс 16 км зайд зайд орших Алтан Нар ордын (“Altan Nar”) шинэчилсэн анхан шатны эдийн засгийн тооцоолол (“АШЭЗТ”) орсон болно. Түүнээс гадна тайланд Баян Хөндийн шинэчлэгдсэн ашигт малтмалын баялаг болон нөөцийн мэдээлэл багтсан. Техникийн тайланг Tetra Tech Inc (“Tetra Tech”) NI 43-101 эрдсийн нөөцийн тайлагналын стандартын (“NI 43-101”) дагуу боловсруулсан. NI 43-101 удирдамжийн дагуу гүйцэтгэсэн Техникийн тайланг 45 хоногийн дотор SEDAR-т бүртгүүлнэ.

**Эх сурвалж:** Erdene.com

**“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци” ХК нь хөндий алтны дүүргийн хайгуул, техникийн хөтөлбөрийн талаар мэдээлэл хийлээ**

“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци” ХК (TSX:ERD | MSE:ERDN) (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани” гэх) нь өөрийн 100% эзэмшлийн Хөндий Алтны Төслийн 2019 оны хоёрдугаар шатны өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүнг танилцуулж, 2019 оны 4-р улирлын өрөмдлөгийн хөтөлбөр эхэлж буйг мэдээлж байна.

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: “Бид хайгуулын хөтөлбөрөөр Баян Хөндий ордын хязгаараас гадна өрөмдлөг хийснээр эрдэсжсэн бүсээ тэлэхийн зэрэгцээ Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд Хар Морь (“Dark Horse”) хэмээх шинэ талбайг нээн илрүүлж, Хөндий Алтны Дүүргийн боломж үргэлжилж буйг бататгалаа. 2015 оноос хойш Эрдэнэ Ресурсийн илрүүлж буй эдгээр нээлтүүд нь Хөндий дүүргийн үр шимийг тодорхойлон харуулсаар байна”.

“2019 оны эцсийн хайгуулын өрөмдлөгийн хөтөлбөр нь энэ долоо хоногт эхэлж байгаа бөгөөд үүнд: Улаан тусгай зөвшөөрлийн талбайг өрөмдөх, саяхан шинээр илрүүлсэн Хар Морь талбайд нэмэлт хайгуул хийх болон геотехник, металлургийн судалгаа багтаж байгаа болно. Эрдэнэ Ресурс нь 2021 онд алтны үйлдвэрлэлээ эхлэхээр төлөвлөж байгаа ба Хөндий Алтны Дүүргийн өнөөг хүртэл бүрэн судлагдаагүй боломжууд нь цаашид биднийг хайгуул хийж, үйл ажиллагаагаа өргөжүүлэх чухал хүчин зүйл болно гэдэгт итгэж байна.”

**Эх сурвалж:** Erdene.com

**“МИК Холдинг” ХК-ийн дүрэмд өөрчлөлт оруулна**

“МИК Холдинг” ХК /MSE:MIK/ дүрэмдээ нэмэлт өөрчлөлт оруулахаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаа 2020 оны 01-р сарын 17-нд хуралдуулахаар болсон байна.

Хурлын шийдвэрийг тус компанийн ТУЗ-өөс өнгөрөгч 10-р сарын 31-ний өдөр гаргасан бөгөөд хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг өдийг 2019.11.22 гэж тогтоожээ.

“МИК Холдинг” ХК /MSE:MIK/-ийн хувьд 200 орчим хувьцаа эзэмшигчтэй ба МХБ-ийн I ангилалд бүртгэлтэй байдаг.

Хувьцаа нь 2019 оны 11-р сарын 8-ны байдлаар 11,000 төгрөгийн ханштай буюу 227.8 тэрбум төгрөгийн зах зээлийн үнэлгээтэй байгаа юм.

**Эх сурвалж:** MarketInfo.mn

**“Монгол савхи” ХК-ийн 3.1% нь 49.8 сая төгрөгөөр арилжигдлаа**

2019 оны 11-р сарын 7-ны арилжаагаар МХБ-ийн үнэт цаасны II ангилалд бүртгэлтэй “Монгол савхи” ХК /MSE:UYN/-ийн нийт хувьцааны 3.1%-тай тэнцэх 76,659 ширхэг хувьцаа арилжигдлаа.

Ингэхдээ худалдан авагч, худалдагч хоёрын хооронд ердөө 1 удаагийн хэлцэлээр зарагдсан бөгөөд хэлцэлийн нэгж хувьцааны ханш 650 төгрөг байв.

Энэ нь 2017 оноос хойш хийгдэж буй томоохон арилжаа болж байгаа ба 2017 оны 6 сард компанийн 35.08%-тай тэнцэх хувьцаа багцын арилжаагаар 486.3 сая төгрөгөөр зарагдаж байсан юм.

Компанийн үйл ажиллагааны тухайд Хан-уул дүүрэгт байрлах өөрийн үл хөдлөх хөрөнгийг түрээслэн орлого олдог. 2019 оны хагас жилд 153.3 сая төгрөгийн орлого олж, -1.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

“Монгол савхи” ХК /MSE:UYN/-ийн 63.29%-ийг 2 томоохон хувьцаа эзэмшигч, үлдсэн 36.71% нь 9,200 гаруй жижиг хувьцаа эзэмшигчдийн мэдэлд байдаг.

**Эх сурвалж:** MarketInfo.mn

**“Монос хүнс” ХК 2019 оны 3-р улирлын тайлангаа нийтэлжээ**

Энэ онд анх удаа хувьцаагаа олон нийтэг санал болгож нээлттэй компани болсон хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Монос хүнс” ХК /MSE: MFC/ 2019 оны 3-р улирлын санхүүгийн тайлангуудаа Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсанд нийтэлжээ.

“Монос хүнс” ХК нь 2019 оны 9-р сарын 30-ны байдлаар 6.8 тэрбум төгрөгийн орлого, 0.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Тус компанийн хувьцаа Монголын Хөрөнгийн Биржийн 2-р самбарт бүртгэлтэй ба 2019 оны 11-р сарын 8-ны өдрийн байдлаар хаалтын ханш 66.9 төгрөг байна.

**Эх сурвалж:** Ти Ди Би Капитал ҮЦК

## ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

**Хүнсний ногоо 90.8 мянган тонныг хураан аваад байна**

Төрийн ордонд 11-р сарын 8-нд чуулсан Хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалагчдын улсын зөвлөгөөнөөр хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалалтад хамтран ажиллах каластрын систем нэвтрүүлэх хэрэгтэй байгааг онцолж байв.

Мөн усалгаат тариалалт, эрчимжсэн аж ахуй хөгжүүлэхийг бодлогоор дэмжих шаардлагатай байгааг хэлэлцлээ. Энэ талаар УИХ-ын гишүүн, ХХААХҮ-ийн сайд Ч.Улаан хэлэхдээ, “Өнөөгийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож буй хэлбэр нь цаг уурын нөлөөллөөс аль болох хохирол бага амсан даван туулахад усалгаат тариалангийн талбайг нэмэгдүүлэх явдал юм” гэдгийг онцолж, эрчимжсэн аж ахуйн хөгжлийг хангах зорилт бол ерөөс дэвшилтэт техник технологид суурилах чухал байна гэв.

Тариалагчдын зүгээс ойрын хугацааны зорилтыг жимс жимсгэнийг дотооддоо зөвхөн ил талбайд тариалаад зогсохгүй, өвлийн хүлэмж барих шаардлагатай байгааг хэлж энэ тал дээр урт хугацаатай, хүү багатай санхүүжилтийн дэмжлэг хэрэгтэй байгааг хэлж байв. Жимс жимсгэний тариалалтад үр, суулгацын чанар, хангамжийг сайжруулах, жимс жимсгэний суулгац үржүүлгийг нэмэгдүүлэх, борлуулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх зэрэг бодлогоор дэмжих олон ажил хүлээж байна.

Манай улс жилд 20-25 мянган тонн жимс жимсгэнэ гадаадаас авч байна. 2025 он гэхэд жимс жимсгэний хэрэгцээний 10 хувийг, 2030 онд 15-20 хувийг дотоодоос хангахаар зорьж байна. Одоогоор манай улсад байгалийн болон тариалсан жимсээр дотоодын хэрэгцээний 7-8 хувийг хангаж байна.

Энэ онд манай улс 189 мянган тонн төмс, 8.3 мянган га талбайгаас 90.8 мянган тонн хүнсний ногоо хураан аваад байна. 2019 онд хүн амын хэрэгцээт төмсийг 100 хувь, хүнсний ногооны 40 хувийг дотоодын тариалалт, үйлдвэрлэлээр хангана. Жимс жимсгэний хувьд 6.4 мянган га талбайд тариалж 3 мянган тонн ургац хураан аваад байна. Энэ онд нийт талбайн 92 хувь нь чацаргана, 4.5 хувийг үхрийн нүд, 3.2 хувийг алим, чавга, бөөрөлзгөнө зэрэг жимс жимсгэнэ эзэлж байна.

**Эх сурвалж:** Montsame.mn

**Рио Тинто: 2020 онд төмрийн хүдрийн нийлүүлэлтээ 5%-аар нэмэгдүүлнэ**

Ирэх онд Рио Тинто групп нь олон улсын зах зээл дэх төмрийн хүдрийн нийлүүлэлтээ 5%-аар нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. Түүнчлэн, 2021 оны эцсээр хүлээгдэж буй шинэ “Koodaideri” уурхайн нэгдүгээр ээлж бүрэн ашиглалтад орсноор тус группын төмрийн хүдрийн нийт олборлолт жилд 360 сая тонн хүрэх боломжтой гэж Рио Тинто-гийн мэдэгдэлд дурджээ. Мөн тус мэдэгдлээр, 2019 онд нийт 320-330 сая тонн төмрийн хүдрийг тонн тутамд 14-15 ам.долларын үнээр нийлүүлэх төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулаагүй байна.

Энэ жилийн эхээр Рио Тинто нь үйлдвэрлэлийн олборлолт төлөвлөлтөөс хоцрогдсоны улмаас Баруун Австралийн уурхайн үйл ажиллагааг зогсооход хүрсэн юм. Уурхайгаас чанар багатай төмрийн хүдэр хэт их хэмжээгээр олборлосноо бууруулж, сайжруулах ажил эрчимтэй явагдаж байгааг группийн Гүйцэтгэх захирал Жан Себастьян Жак мэдэгджээ.

2019 онд компанийн нийт хөрөнгийн зардал 5.5 тэрбум доллар болж бууруулсан бол 2020 онд 7 тэрбум ам.доллар болгож нэмэгдүүлэх аж. Харин 2021, 2022 онд 6.5 тэрбум орчим ам.долларын зардлыг урьдчилан тооцоолж байна.

**Эх сурвалж:** MongolianMiningJournal.com

**ОХУ: 2025 онд Энэтхэг улсад 28 сая тонн нүүрс экспортолно**

ОХУ 2025 онд Алс Дорнодын нутгаар Энэтхэг улсад нүүрсний экспортоо 6 дахин нэмэгдүүлж 28 сая тоннд хүргэхээр төлөвлөжээ. Энэ тухай Алс Дорнодын хөгжлийн сайдын нэгдүгээр орлогч Сергей Тырцев “Орос-Энэтхэгийн нүүрсний төслүүд” бага хурал дээр мэдэгдсэн байна.

Алс Дорнодын холбооны тойрог нь нүүрсний олборлолтын хэмжээгээр ОХУ-д хоёрдугаарт ордог бүс нутаг юм. Өнөөгийн байдлаар тус бүс нутагт томоохон 10 уурхайгаас нүүрсний гол олборлолт хийгдэж байна. 2018 онд Алс Дорнодын нутгаас 4.5 сая тонн нүүрс Энэтхэгийн зах зээлд экспортолжээ.

“Орос-Энэтхэгийн нүүрсний төслүүд” бага хуралд оролцсон Энэтхэгийн нефть, хий болоод гангийн сайд Дармэндр Пратхан “Манай улсын дан ганц хөнгөн цагааны үйлдвэрлэлд 70 сая тонн коксжих нүүрсний дутагдалтай байна. Зөвхөн гангийн үйлдвэрлэл гэхэд жилд 55 сая тонн коксжих нүүрс ашиглаж байгаа юм. Өнөөдөр Энэтхэг улс нь дэлхийн нүүрсний хоёр дахь импортлогч орон. 2030 он гэхэд жилд 3 сая тонн ган үйлдвэрлэх хэмжээнд хүрэх тул нүүрсний импортыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага бий” гэдгийг онцолжээ.

**Эх сурвалж:** MongolianMiningJournal.com

### МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.